

**“Зээгт ав” хэмээх нэр томъёоны тухайд**

**Ц. Шагдарсүрэн**  
(МУИС)

- I. “Зээгт ав” хэмээх нэр томъёоны тухайд
- II. “Зээгт ав”-ын талаархи эрдэмтэдийн судлагаа
  - II. 1. “Зээгт ав” гэж чухам юу юм бэ?
  - II. 2. “Зээгт ав” гэдэг нэр томъёог тайлбарласан байдал
- III. Монгол хэлний үгсийн сангаас сөхөн мөшгих нь
- IV. Дүгнэн нэмэж хэлэх санаа оноо, таамаг

I. Эртний монголчуудын нэгэн хэсэгийнхний эрхилэж ирсэн гол аж ахуй нь ан авын зүйл байсан<sup>1</sup> бөгөөд үүний ул мөр өдгөө хүртэл монголчуудын, тэр тусмаа Буриад монголчуудын аж амьдрал болон үгсийн сангийн хүрээнд идэвхитэй уламжлан ирсэн байдаг. Үүнд давын өмнө хамаарах нэгэн нэр томъёо бол даруй “зээгт ав” (Mo. *jegeg-tü aba*, Орос, Буриадын эрдэмтэдийн ном бүтээлд *Зээгтэ-аба* [? Ц. Ш.] болно.

Энэхүү “зээгт ав”-ын талаар бичиж тэмдэглэсэн, судласан зүйл XIX зуунаас эхлэн гол төлөв буриад эрдэмтэдийн бүтээлд түлхүү байр суурь эзлэдэг бөгөөд үүнд, “зээгт ав” хэмээх нэр томъёо, түүний уг утга учир, хэрхэн үүссэн талаар тайлбарлан бичсэн зүйл нэлээд буй<sup>2</sup> боловч алтай овогийн бусад хэлний хажуугаар монгол хэлний түүхэн үгсийн сан болон түүхэн утгазүйн үүднээс эргэж нягтлаваас зохилтой гэж санагддаг зүйл бас байна.

<sup>1</sup> Б. Я. Владимирцов, *Общественный строй Монголов, Монгольский кочевой феодализм*, Ленинград, 1934, стр. 33-46; В. Vladimirtsov, *Le régime social des Mongols*, Trad. Par M. Carsow, Paris, 1948, pp. 39-56.

<sup>2</sup> М. Н. Хангалов, *Зээгтэ-аба – облага на зверей у древних бурят* – Известия Восточно-Сибирского Отдела Императорского Русского Географического Общества, XIX, № 3, 1888, стр. 1-22 [См. М. Н. Хангалов, *Собрание сочинений*, Том I, Улан-Удэ, 1958, стр. 11-32]; Д. А. Клеменц, М. Н. Хангалов, *Общественные охоты у северных бурят, (Зээгтэ-аба – охота на росомах)* – Материалы по этнографии России, N. 1, Издание Этнографического Отдела Русского Музея Императора Александра III, Санкт. Петербург, 1910, стр. 117-154; В. А. Михайлов, *Заметка по поводу перевода выражения “зээгтэ-аба” – охота на росомах в статье М. Н. Хангалова, Д. А. Клеменца “Общественные охоты у северных бурят”* – Живая старина, 1913, N. 1, (Вып. 1-2), стр. 181-182; А. И. Балдунников, *К вопросу о задачах историко-этнографического исследования бурят*, – Бурятияведение, Улан-Удэ, 1928, N. 1-3 (5-7) стр. 20-41; П. Т. Халтаев, *Краткий очерк Бурят-Монгольского народа*, Улан-Удэ, 1942, стр. 12-13, 16; Т. А. Бертагаев, *Лексика монгольских языков*, – Докторская диссертация, Москва, 1946, 284 стр.; С. П. Балдаев, *Несколько замечаний о “зээгтэ-аба”* – Кратк. Сообщ., Буриятский комплексный научно-исследовательский институт (БКНИИ), Серия Ист.-филол., Улан-Удэ, 1962, Вып. 4, стр. 97-99; Ш. Н-Р, Цыдэнжапов, *О происхождении устойчивого словосочетания “зээгтэ аба”*, – Материалы первого республиканской конференции молодых учёных по общественным наукам, Улан-Удэ, 1973, стр. 302-306; Д. Гонгор, *Монголия в период от родового строя к феодализму*, Автореферат докторской работы, Улан-Батор – Москва, 1974, стр. 34-35; N. Ts. Мынкуюев, *A Mongolian Hunting practice of the 13<sup>th</sup> century and the Buryat terms Zeegete aba and aba khaidag*, – Tractata Altaica, By Denis Sinor, Wiesbaden, 1976, pp. 417-433; Д. Гонгор, *Халх товчоон, II боть, Улаанбаатар, 1978, 351-361-р тал; С. Г. Жамбалова, Традиционная охота Бурят*, Новосибирск, 1991, 175 стр., см. Стр. 85-100; Д. Гонгор, *Халх товчоон, II боть, Улаанбаатар, 1978,*

Монгол ардын аман домогийн хэрэглэгдэхүүнээс үзвэл монголчуудын уламжлалт ан агнуурын энэхүү "зээгт ав" гэдэг нэр томъёо бол үлэмжхэн эртнээс уламжлаж ирсэн гэж үзэх баримт буй. Тухайлбал: Бөөгийн шашины 99 тэнгэр нэр хэрхин (Буриад домогтоо Хан Түрмэс гэдэг нэрээр гардаг) Хан Хурмаст Тэнгэр тэргүүтэй цагаан зүгийн 55 Тэнгэр, Атаа Улаан Тэнгэр тэргүүтэй харын зүгийн 44 Тэнгэрт хуваагдсан тухай буриадын нэгэн домогт өгүүлсэн байдаг бөгөөд энэ домогийн орос орчуулгаас нь монголчилон толилуулбал:

"Нэгэн удаа Асаранги хэмээгч Их бөөтөний удирадсан том **зээгт ав** болжээ. Энэ авын ич (оросоор *правый*) жигүүрийг Хан Түрмэс бөө, сол (оросоор *левый*) жигүүрийг Атаа Улаан бөө удирадсан гэнэ. Тэгээд Их бөөтөн Асаранги-ийг насан эцэслэсэний дараа Хан Түрмэс, Атаа Улаан хоёр бөө Их бөө болох гэж өвөр зуураа маргалдаад **зээгт ав** ч бас хоёр хуваагдаж гэнэ.

Ингээд **зээгт ав** -ын ич жигүүрийг Хан Түрмэс тэргүүлж тавин дөрвөн Их бөө болон тэдний ангуучид дагалдах болжээ. Сол жигүүрийг Атаа Улаан тэргүүлж дөчин гурван Их бөө ангуучидынхаа хамт дагалдах болжээ.

Эдгээр бөө нарын сүнсийг Дээд Тэнгэр-нэр хэмээн буриадууд үздэг бөлгөө. Хан Түрмэсийг дагалдсан тавин дөрвөн Их бөөгийн сүнс Хан Түрмэсийнхитэй нийлэн барууны (оросоор *западный*) тавин таван Тэнгэр болжээ. Атаа Улааны талд орсон дөчин гурван бөөгийн сүнс Атаа Улааныхитай нийлэн зүүний (оросоор *восточный*) дөчин дөрвөн Тэнгэр болжээ. Барууны тавин таван Тэнгэр нь цагаан буюу сайн зүгийн (оросоор *добрые*), Зүүний дөчин дөрвөн Тэнгэр нь харын буюу муу зүгийн (оросоор *злые*) Тэнгэр-нэр болсон ажээ..."<sup>3</sup>

Үүнээс үзэхэд утга санаа нь тодорхой бөгөөд "**зээгт ав**" гэдэг зүйл нэн эртний уламжлалтай, тухайн нийгэмийн аж амьдралд үлэмжхэн үүрэгтэй байсаныг харуулж байна. Орчуулах явцад, зарим тохиолдолд үгчилэн орчуулж болдог, заримдаа утгачилан орчуулахаас өөр аргагүйд хүрдэг, учир дээрхи орчуулгын дотор дүйлгэсэн орос үгий нь хаалтанд нэмэн хийсэн болно. Энэ таширамд онцлон тэмдэглэх нь: оросоор орчуулахад монгол хүний зүг чиг заах ёсон орос хүнийхитэй зарим тохиолдолд таардаггүй гэдэгийг санаж явбал зохино. Тухайлбал: монголчуудын *моринь зөв тал, буруу тал* гэдэг нь ертөнцийн зүг чигтэй таардаггүйн дээр орос болон европ хүний зүг чигтэй зөрдөг бөлгөө. Мөн түүнчилэн оросоор *Забайкалье, Прибайкалье ...* зэрэг орон зайн хамаарал бүхий нэр томъёог зохиогч, орчуулагч болоод уншигч хүмүүн ямар нөхцөлд, хаана байж байгаагаас шалтгаалан, эхний нэрийг наад зах нь *Байгалийн чанад, Байгалийн янад (этгээд)* гэх зэрэгээр өөр өөрөөр бичих, орчуулах хэрэгтэй болдог. Бас ертөнцийн зүг чигийн байршилаар нь *Өвөр байгаль* гэх боломж ч бас буй. Ертөнцийн зүг чигээр ингэж орчуулах нь суурин бус, ертөнцийн зүг чигээр баримжаалдаг нүүдэл иргэдэд илүү ойлгомжтой ч байж мэднэ. Иймээс зан үйлийн нарийн ширийн зүйлийг оросоос монголчилох, монголоос оросчилох, ер нь зөвхөн орос хэлний тухайд ч бус, шашин сэтгэлгээ өөр ард түмний ямар ч хэлнээс бие бие-рүү нь орчуулах зэрэгт энэ мэт ялгааг сайтар бодолцох шаардалгатай гэдэгийг онцлон тэмдэглэсү.

Энэхүү домогоос үзэхэд "**зээгт ав**" гэдэг зүйл монгол туургатны хувьд маш эртний улбаатай, уугуул аж амьдралын үндсэн үйл ажиллагаа байсан нь тодорхой харагдана. Тэгвэл эртний улбаатай энэхүү нэр томъёо чухам юуг зааж байв? Монгол хэлний судлагааны үүднээс хэрхин үүсэв? гэх зэрэг олон асуудал түрүү үеийн судлагчдын дунд нэгэн мөр бололгүй өдгөөг хүрсэн тул түүнийг их бага аль нэгэн хэмжээгээр тодруулах зуланд нь тос нэмэхийн төдий, монгол хэлний холбогдох баримт сэлтийг нэмэхсэн гэж бодсон ч, зарим үзэж нягтлах зүйл уг эхээрээ олдохгүй байсаар хэдэн жилийн нүүр үзэж, сая нэг бичих нөхцөл тохиол бүрдэв.

II. "**Зээгт ав**" хэмээх энэхүү нэр томъёог судлаж тайлбарласан байдалыг үзвэл судлагчид одоо болтол нэг мөрийн саналд хүрч ац хагалаагүй, янз бүрээр тайлбарласаар зуу гаруй жилийн нүүрийг үзжээ. Үүнд: судлагч нэг бүрээр ярих боломжгүй тул гол гол саналыг нэгэдхэн тоймлож товч танилцуулахыг хичээв. Гэхдээ давын өмнө чухам ямар авыг ийнхүү

<sup>3</sup> П. Т. Хаптаев, *Краткий очерк Бурят-Монгольского народа*, Улан-Удэ, 1942, стр. 16.

нэрлэж байв гэдэг талаар эс яриваас уг нэр томъёоны мөн чанарыг гаргахад учир дутагдалтай болох буй заа.

II. 1. “Зээгт ав” гэдэг нэр томъёо ер нь ямар зүйлийг хэлдэг байв? Энэ талаар хамагийн анх 1888 онд М. Н. Хангалов (1858-1918)-ын дэлгэрэнгүй судлагаа гарсан бөгөөд буриадын соёлын түүхэнд товч тодорхой дүрслэсэн эрдэмтэн бол П. Т. Хаптаев болно (2-р зүүлтээс тодруулан үзмүү). Хэдийгээр П. Т. Хаптаевын бүтээл буриадын нийгэм-соёлын түүхэнд холбогддог, түүнд “Зээгт ав” –ын талаар миний бодоход хамагийн тодорхой баримт судлагаа байдаг боловч сүүлийн үед ЗХУ-д гарсан буриадын ан авд шууд холбогдох эрдэм шинжилгээний бие даасан ном зохиолд дураддаггүй, номзүйд нь ч багтдаггүй юм.

Буриадын хэд хэдэн овогийнхин нэгдэж нэгэн зүйл ав хоморго хийхийг “Зээгт ав” гэдэг байжээ. Тэхдээ бүр эхин үедээ цөөн хүнтэй байсан нь мэдээж бөгөөд яв явсаар нэн олон хүнийг хамарсан, нарийн зохион байгуулалт бүхий ав хоморго болсон нь тодорхой бөлгөө. Түүхэн баримт сэлтээс үзэхүл Хүннү-гийн үе гэхэд, тодруулан хэлбэл христусын тооллын өмнөхи 160 онд Модун шаньюй (хаан) зуун мянган хүнтэй Их ав хийсэн тухай нангиадын түүхэнд тэмдэглэсэн нь буй<sup>4</sup>. Арай хожуу үеийн баримт гэхэд, 1221 оны өвөлийн дундуур Тэрмэд (?) гэдэг газар Чингис хаан бүх цэрэгээ хамарсан Их ав хийсэн тухай дорно дахиныг судлагч, англи эрдэмтэн Жон Ранкинг (John Ranking) 1826 он Лондон хотноо нийтлүүлсэн томоохон бүтээлдээ дураджээ<sup>5</sup>. Энэхүү түүхч уг бүтээлийнхээ 1-р бөлөгт “Зээгт ав” гэж юу байсан талаар тодотхох судлагаа баримтыг *An Imperial Hunting circle*<sup>6</sup> гэдэг нэрээр бие даасан бөлөг болгон оруулсан байдагийг хэлэх хэрэгтэй буй заа. Бас Ази болон Европ дахины жуулчид ч тэмдэглэлдээ марталгүй оруулжээ. Нангиадын түүхэн тэмдэглэлүүд, тухайлбал: 1237 оны “Хар Татарын тэмдэглэл” (黑韃事略) гэдэг номдоо зохиогч (彭大雅 англи галигаар P'eng Ta-ya, 徐靈 Hsü T'ing) нар 1233-1236 онд Өгөөдэй хааны ордонд байх үес, Хар Татар буюу Чингисийн монголчуудын ан агнуури, ав хоморгыг үзэж харсан тухай тодорхой баримт мэдээ оруулсан байдаг. Эдгээр тэмдэглэл нь бидний судлагдахуун болж буй “Зээгт ав”-ын төлөв байдалыг улам тодруулахад туслана<sup>7</sup>. Үүнээс гадна монголчуудын ан ав, хийгээд түүнд хэрэглэж байсан зэмсэг хэрэглэл, арга ухааны талаар монгол хүний бичиж тэмдэглэсэн боловч хэвлэгдэж нийтийн хүртээл болж амжаадгүй бүтээл энд тэнд гар бичмэл байдалаар хадгалагдсаар буй. Үүнд: ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн номын санд агч ахмад түүхч С. Төмөр-очир авгайн “Эртний монголчуудын ан агнуурийн зарим багаж зэвсэг, арга барилын тухай” гэдэг монгол бичигээр буй гар бичмэл хадгалагдахууныг жишээлэн дурадаж болно. Энд *томог занга* (Mo. *tomuy jangγ-a*) болон буриадын “зээгт ав”-ын холбоо гарал, хөгжил хувиралын талаар тодорхой тайлбарласан хэсэг буй.

Иймэрхүү олон хүнийг хамарсан ав хоморго нь тухайн цагтаа нийт монгол туургатаны хувьд, аж ахуйн гэхээсээ илүү цэрэг эрсээ харвах намнах, хөдөө гадаа олон хоног сараар хээрлэн явах, зэлүүд хүнгүй газар баримжаа олох, морин эрдэмд боловсруулах зэрэг тухайн цагийн цэрэг эрд шаадалгатай бүхий л дадалга суулгах гол арга болж байсан ажээ<sup>8</sup>. Өөрөөр хэлбэл, өдгөөгийн нэгэн ёсны цэрэгийн сургуультай адилхан байсан бөлгөө. Буриадуудын хувьд ч мөн ийм байсан бөгөөд “Зээгт ав” нь орон суурин газараас хол, олон өдөр сараар хөдөө хээр үргэлжлэх бөгөөд энэ далимаар дайсагнагч овог аймагаа уулгалан довтлож эд юмсы нь хураан авдаг байсан тухай олон аман баримт байдаг байна<sup>9</sup>.

<sup>4</sup> *Материалы по истории Сюнну* (по китайским источникам), предисловия, перевод и примечание В. С. Таскина, Москва, 1973, стр. 30.

<sup>5</sup> John Ranking, *Historical Research on The Wars and Sports of the Mongols and Romans: in with Elephants and Wild Beasts were employed or slain and the Remarkable local agreement of history with the remains of such animals found in Europe and Siberia*, London, M.DCCC.XXVI, p. 31.

<sup>6</sup> John Ranking, *Historical Research on The Wars and Sports of the Mongols and Romans:...*, London, M.DCCC.XXVI, pp. 31-36.

<sup>7</sup> N. Ts. Münküjev, *A Mongolian Hunting practice of the 13<sup>th</sup> century and the Buryat terms Zeegete aba and aba khajdag*, - *Tractata Altaica*, By Denis Sinor, Wiesbaden, 1976, pp. 417-433 pp. [Cf. 421-422.]

<sup>8</sup> Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын утаа соёлын товчоон*, Улаанбаатар, 2003, 190-193-р тал.

<sup>9</sup> П. Т. Хаптаев, *Краткий очерк Бурят-Монгольского народа*, Улан-Удэ, 1942, стр. 13.

“Зээгт ав”-ын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчим нь монгол цэрэгийн цэрэглэх ухааны олон арга<sup>10</sup> дотороос *нуман түлхүүр, бух сэжүүр* хэмээх аргыг эрхгүй санагдуулдаг бөгөөд энэ талаар эрдэмтэдийн ажин тэмдэглэсэн зүйл ч буй<sup>11</sup>.

“Зээгт ав” гэдэг нь ан гөрөөс бүхий ой мод, уулыг нэг төвөөс хоёр жигүүр болон тал тойрон бүслээд явц дунд уулзаж, хүрээгий нь багасхан хумин хумисаар хоморгод орсон ангаа агнаж, хүн бүр оногдох хувиа авдаг, тодорхой дохиогоор тардаг нарийн зохион байгуулалт бүхий авын арга бөлгөө. Үүнд эмэгтэйчүүд ч эрэгтэйчүүдийн нэгэн адил эрх тэгш оролцдог байсан гэлцэнэ. Үргэлжлэх хугацааны тухайд, XVIII-XIX зуун гэхэд Хори буриад нутагт 1000 хүнтэй их ав хоморго хоёр долоо хоногос хоёр сар болдог байсан баримт буй<sup>12</sup>.

“Зээгт ав”-ыг бүр эхэндээ Бөө нар тэргүүлдэг байсанаа тэрхүү эрх мэдэл нь аажимаар тухайн үеийнхээ нийгэмийн шаардалгаар цэрэгийнхинд шилжисэн байна.

“Зээгт ав”-ыг ерөнхийд нь авын *галч* (буриадаар *галша*) хэмээх хүн мэдэж удирдана. Түүний дараагийн мэдэлтэн нь *товч* (буриадаар *тобша*) бөгөөд авын хоёр жигүүрийг уулзуулах гол үүрэгтэй. Дараагийн мэдэлтэн нь хоёр жигүүрт нэгжээд байх *газарч* (буриадаар *газарши*) болно. Заримдаа түүнийг *гар бариач* (буриадаар *гар баряши*) гэнэ. Хоёр жигүүрийн *газарч* буюу *гар бариач* нь тухайн орон газар, нутаг усаа арван хуруу мэт хамагийн сайн мэддэг байх ёстой бөлгөө.

“Зээгт ав”-д оролцогч бүх овог аймагууд хэд хэдэн бөлөг болж нэгдэх бөгөөд бөлөг тус бүрийг *засуул* толгойлдог байна.

Тэдгээр бөлөгүүд дотор дотороо хэд хэдэн хэсэгт хуваагдана. Хэсэг бүрийг *малагай* гэдэг тусхай хүн мэдэж удирдана.

Тухайн үеийн нийгэмийн шаардалгаар “Зээгт ав”-ын дээр дурадсан бүх зэрэг дэвийн удирдагч толгойлогч нар зөвхөн авын үед төдийгүй, ер энгийн аж амьдралын үед ч, эгзэгтэй цэрэг дайны үед ч ямагт өөр өөрийн тэргүүлэх үүрэгээ гүйцэтгэдэг байжээ. Тийм ч учираас анх бөө нарын эзлэж байсан удирдах үүрэгийг цэрэгийнхин тэргүүлэх болсоны учир начир нь тэр бөлгөө.

Иймэд “Зээгт ав”-ыг зохион байгуулагч нарын алба тушаалын нэр ус нь өөр болдог байсан байж болох боловч удирдан тэргүүлэх үүрэг нь айван тайван аж төрөл, шахамдан тулгамдсан дайн самууны үед ч хэвээрээ байсан гэж үзэх бүрэн үндэстэй юм.

Үүнээс гадна, Их ав болон “Зээгт ав”-ыг зохион байгуулт, дотоод бүтэцтэй холбоо бүхий авын *төв* буюу *авын гал*, *авын гар* буюу *авын жигүүр*, *авын сүвээ* (дотороо: *гол сүвээ*, *торгон сүвээ*), *цуваа*, *үзүүр годоли*, *авын от*; *ав тавихуй*, *ав хураахуй* буюу *ав тарахуй* гэх зэрэг олон нэр томъёо<sup>13</sup> буй боловч энэ удаа сэдэвтээ захирагдан тэр бүрийг нарийсхан тайлбарлахыг чармайсангүй.

“Зээгт ав”-аас гадна буриадад нийтийг хамарсан ан агнууртай холбогдол бүхий *ав хайдаг* (буриадаар *аба хайдак*), *хайгт ав* (буриадаар *хайгта аба*), *хошуут ав* (буриадаар *хушуута аба*), *галчит ав* (буриадаар *галшата аба*) гэх зэрэг өөр хэд хэдэн нэр буй. Эдгээрээс эхиний хоёр буюу “зээгт ав”, “ав хайдаг”-ийг судлагчид түлхүү анхаарч, өвөр зуураа чухам ямар ялгаатай болохыг тодруулах гэж оролдсон гэдэгийг хэлэх хэрэгтэй<sup>14</sup>.

<sup>10</sup> Х. Пэрлээ, *Монгол цэргийн уран чадвар*, - Шинжлэх ухаан, 1942, N. 5, Улаанбаатар; *Chinggis Khan, The Golden History of The Mongols*, Translated and with an introduction by Urgunge Onon, London, 1993, [Cf. Appendix B: The Arts of War under Chinggis Khan, pp. 175-182].

<sup>11</sup> Д. Гонгор, *Халх товчоон*, II боть, Улаанбаатар, 1978, 355-р тал.

<sup>12</sup> В. А. Михайлов, *Оружие и доспехи бурят*, Улан-Удэ, 1993, 71 стр, См. стр. 51.

<sup>13</sup> Ц. Жамцарано, *Об облавах у Ордосцев*, - *Studia Mongolica*, T. I, Fasc. 6, Улаанбаатар, 1960, 4 стр.; Д. Гонгор, *Халх товчоон*, II боть, Улаанбаатар, 1978, 354-р тал.

<sup>14</sup> N. Ts. Munküeyev, *A Mongolian Hunting practice of the 13<sup>th</sup> century and the Buryat terms Zeegete aba and aba khaidag*, - *Tractata Altaica*, By Denis Sinor, Wiesbaden, 1976, pp. 417-433; Д. Гонгор, *Халх товчоон*, II боть, Улаанбаатар, 1978, 355-361-р тал. С. Г. Жамбалова, *Традиционная охота Бурят*, Новосибирск, 1991, 175 стр., см. Стр. 85-100.

Бас [шинэ үсэгийн дүрэмээр “зөв” бичвэл том, монгол хэлний зүйгээр зөв бичвэл, том (Mo. tomu) багаас ялгаж тома гэж бичдэг] тома ав гэдэг нэгэн зүйл ав байсан бөлгөө. Эл тома гэдэг үгийг “Гучинзургаат тайлбар толь”-ийн Газарын зүйл-д “...гөрөөс явсан зам...” хэмээн тайлсан байх тул энэ нь даруй мөр мөшгиж агнахыг хэлсэн нь тодорхой болоод ирнэ. (Өдгөө олонхи залуусын хэлний боловсролд тааруулж нэхэн тайлбарлах шаардалга нэгэнт буй болсон тул, гөрөөс гэдэг үг угтаа ан гэсэн утгатай, тэгээд ч гөрөөчин гэдэгийг энд ташрамдуулан нэмж дурадсу.)

Олоныг хамарсан ав хоморгод холбогдох дээр дурадсан нэр томъёонууд тус бүр чухам ямар зүйлийг зааж ирсэн, өвөр зуураа ямар ялгаатайг гаргах зорилгоор судласан зүйл нэлээд буй боловч эрдэм шинжилгээний үндэслэгээний хувьд нягтлууштай зүйл бас багагүй хэмээн хэлж болно. Тухайлбал: 1923 онд Эрхүү мужийн Бохан-ы дүүрэгт хийсэн судлагааныхаа дүнд үндэслэж А. И. Балдунников “...Хэрэвзээ авд 300 хүртэлхи хүн оролцох бөгөөс “зэгэтэ аба”, 500 хүртэлхи хүн оролцох бөгөөс “нагта аба” гэнэ...”<sup>15</sup> гэж үзсэн байх ба оролцогчийн тооноос шалтгаална гэсэн энэ саналыг нь хүлээн зөвшөөрч үргэлжлүүлэхдээ С. П. Балдаев “...Байгал орчимын буриадууд 300 харваач оролцсон авыг “зэгэтэ аба” гэдэг бол Байгалын чанадын буриадууд “аба хайдак” гэнэ. 500-аас дээш харваач оролцсон авыг “хушуута аба”, 1000 гаруй харваач оролцвол “галшата аба” гэдэг...”<sup>16</sup> гэж нутагийн аялгууны ялгамжаатай холбон нэмэж тайлбарласан байдаг.

Ийнхүү авд холбогдох нэр томъёог оролцогчийн тоогоор хэмжүүр хийж тайлбарлах нь эргэлзээтэй гэдэгийг С. Г. Жамбалова тэмдэглэж, бас аман зохиолын баримтад үндэслэн “зэгэтэ аба”, “аба хайдак” хоёр бол нутагийн аялгууны ялгаа бус, уулаасаа хоёр өөр зүйл, харин “аба хайдак”, “нагта аба” (буюу *хайгта аба* [Ц. Ш.]) хоёр бол нэгэн ухагдууныг тэмдэглэсэн хувилбар нэр томъёо юм<sup>17</sup> гэж үзсэн байх ба энэ өгүүлэлийг бичигч миний бие ч үүнтэй санал нэгдэж байна.

II. 2. “Зэгэтэ ав” хэмээх нэр томъёог монгол хэлний талаас нь судласан байдалыг үзвэл хэдэн гол ялгаатай санал харагддаг. Энэ талаар товчилон базаж танилцуулая. Хэдийгээр буриад эрдэмтэдийн оросоор бичсэн бүтээлд уг нэрийг “зэгэтэ аба” гэж 1888 оноос буюу М. Н. Хангалов профессороос эхлэн нэгэдмэл бичиж байгаа боловч уг нийлмэл нэр томъёоны эхний хэсэгийг, хэдийгээр хүлээн зөвшөөрөхөөргүй боловч “зээх” (Mo. *jigeke*) буюу “нохой зээх” (Mo. *noqai jigeke*) гэдэг амьтантай холбон тайлбарласан зүйл байх тул буриадын аман дуудалгад тухайн үгийн эхин үеийн –э– эгшиг нь урт болохыг даруй батлаж байгаа хэрэг билээ.

II. 2. 1. “Зэгэтэ ав” хэмээх нэр томъёог анх хэлний талаас нь судласан эрдэмтэн бол М. Н. Хангалов бөгөөд “зэгэтэ” хэмээх үгийг дээр дурадсанчилан оросоор *россомаха*, *рос(с)омашья*, *росомаха*, англиар *glutton*, америкийн англиар *wolverine*, монголоор зээх (Mo. *jigeke*) буюу “нохой зээх” (*Gulo gulo* / *Gulo Linnaeus* / *Gulo Sibiricus* ...) гэдэг амьтаныг агнахтай холбоотой<sup>18</sup> гэж үзсэн бөгөөд үүний нь зарим судлагчид, тухайлбал: тользүйч К.М.Чермисов хүлээн зөвшөөрч “Буриад орос толь”-доо тэр хэвээр нь оруулсан байдаг билээ<sup>19</sup>. Гэвч уг саналыг үл зөвшөөрөх судлагчид цөөнгүй гардаг. Үүнд: Орос, Зөвлөлтийн эрдэмтэн И. А. Подгорбунский, С. П. Балдаев, Т. А. Бертагаев, Ш. Н-Р. Цыдэнжапов болон Монголын эрдэмтэн Д. Гонгор нарыг хамааруулж болно. Гэхдээ зарим нь, “зээгт” гэдэг үгийг монгол үг биш, түрэг зүгийн хэлний үг, тийм болохоор “Зэгэтэ ав” гэдэг нь түрэг монгол “эрлийз” (гибрид) нэр томъёо гэж үзсэн байдаг. Тухайлбал: Ш. Н-Р. Цыдэнжапов “зэгэтэ” гэдэг үгийг түва хэлнээс орж ирсэн “ан ав” гэдэг утга бүхий “сэгит” гэдэг үг хэмээн үзээд түрэг монгол хоёр хэлний нэг утга бүхий

<sup>15</sup> А. И. Балдунников, *К вопросу о задачах историко-этнографического исследования бурят*, - Бурятияведение, Улан-Удэ, 1928, N. 1-3 (5-7) стр. 20-41, См. стр. 32.

<sup>16</sup> С. П. Балдаев, *Несколько замечаний о “зэгэтэ аба”*, - Кратк. Сообщц., БКНИИ, Серия Ист.-филол., Улан-Удэ, 1962, Вып. 4, стр. 97-99, См. стр. 97.

<sup>17</sup> С. Г. Жамбалова, *Традиционная охота Бурят*, Новосибирск, 1991, 175 стр., см. Стр. 87.

<sup>18</sup> М. Н. Хангалов, *Зэгэтэ-аба – облава на зверей у древних бурят – Собрание сочинений*, Том I, Улан-Удэ, 1958, стр. 12; Д. А. Клеменц, М. Н. Хангалов, *Общественные охоты у северных бурят, (Зэгэтэ-аба – охота на росомах)* – *Собрание сочинений*, Том I, Улан-Удэ, 1958, стр. 54.

<sup>19</sup> К. М. Черемисов, *Бурятско-русский словарь*, Москва, 1973, стр. 275.а.

хоёр үгээс бүтжээ гэж дүгнэсэн байдаг<sup>20</sup>. Өөр аль нэг хэлнээс нөгөө хэлэнд үг орно гэдэгийг нягтлан үзэх бөгөөс анхаарах хэдэн зүйл буй. Тухайлбал: аль ч үндэстэний хувьд бие эрхтэн, тоо, хэн бүхэний нүдэн дээр ил байдаг байгал ертөнцийн юм үзэгдэл, уугуул шашин мөргөл, уугуул зан үйлд шууд холбогдох бодат зүйл болон үйл хөдлөлийн нэр өөр хэлнээс орж ирэх магадлал бараг байдаггүй бөгөөд хэлний энэхүү онцлогт шүтэж төрөл хэлнүүдийн салсан он цагийг бодож гаргах судлагааны нэгэн аргыг профессор Моррис Сводеш (Morris Swadesh)<sup>21</sup> гаргаж түүний нь хэрэглэн Алтай овогийн хэл болон монгол хэлний салсан он цагийг монголч эрдэмтэд тодорхойлсоор ирсэнийг бид бэлхэнээ мэдэх билээ. Учир иймээс “Зээгт ав” гэдэгийг “эрлийз” нэр томъёо гэхэд эрхгүй эргэлзээ төрнө. Тэгэхдээ энэхүү эргэлзээ маань нэг овог хэлний хувьд үгийн гарал нийтлэг байж болохыг үгүйсгэж буй хэрэг огт биш гэдэгийг онцлон тэмдэглэе!!!

II. 2. 2. Хоёр нэрээс бүтсэн “Зээгт ав” хэмээх нэр томъёоны нэгдүгээр үг нь судлагчидын анхааралыг татдаг бөгөөд уг нэр үгийг М. Н. Хангаловын тайлбараас өөрөөр үзсэн зүйл хэд хэд буй боловч тэр бүрийг энд ярилгүй, хэлшинжлэл, утгасудлал, уламжлалт зан заншилын талаас илүү үндэстэй гэж үзсэн буюу монгол хэлний (одоо халхын аялгуунд идэвхитэй хэрэглэгдсээр буй) “зээг” гэдэг үгтэй холбон тайлбарласан эрдэмтэдийн саналыг арай дэлгэрэнгүй тайлбарлах нь зүйтэй болов уу гэж бодлоо.

Монгол хэлний “зээг” гэдэг үгийг Я. Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь”-доо монгол бичигээр (Mo. *jegeg*) хэмээн бичдэг, хоёр гол утга илэрхийлнэ хэмээн үзэчихүй. Үүнд:

ЗЭЭГ I 1. зарим эдлэл юмны захаар нь тойруулан хадсан, оёсон дээс утас мэт юм; дээврийн зээг, ширдэгийн зээг; 2. нарийн дээс; зээг томох. (Mo. *jegeg*)

ЗЭЭГ II хэц, зэл.

хэмээн тайлсан байна.<sup>22</sup>

Дээр өгүүлсэнчилэн ийм тайлбар бүхий “зээг” гэдэг үгийг бидний санахад, монгол хэлний авиазүй, үгзүй буюу бүтэц судлал, утгазүй болон уламжлалт зан үйлийн үүднээс “зээгт ав” хэмээх бидний судлагдахуунтай шууд холбон үзэхэд ямар нэгэн эргэлзээ төрүүлэхгүй гэж санаж байна.

“Зээгт ав” хэмээх нэр томъёог 1946 онд эрдэмийн зэрэг хамгаалсан бүтээлдээ Баруун буриадын бөөгийн зан үйл болон Халхын аялгууны энэхүү “зээг” гэдэг үгтэй анх холбон тайлбарласан эрдэмтэн бол Т. А. Бертагаев профессор байсан билээ<sup>23</sup>.

Монголын нэрт түүхч Д.Гонгор докторын зэрэг горилож бичсэн зохиол болон “Халх товчоон” хэмээх хоёр боть шилдэг сайн бүтээлдээ нэн өргөн, олон талт асуудалыг хамарсаны нэг нь монголчуудын ав хоморго, түүний дотор судлагчдын анхааралыг татсаар ирсэн “зээгт ав”, “хайдаг ав”-ын талаар монгол хэлний түүхэн үгсийн сан, нутагийн аялгууны баримт, түүхэн сурвалж, нангиадын түүхэн тэмдэглэл, уламжлалт зан үйл, хадны сүг зураг болон нийтийн хүртээл болж чадаагүй байсан гар бичмэл судлагаа<sup>24</sup>-ны мэдээ занги гэх зэрэг олон талаас нь судлаж монголчууд ан агнуурийн үйл ажиллагаандаа “зээг” хэмээх хэц, зэл ашиглаж байсаныг олон баримтаар батлаж өгсөн байна<sup>25</sup>.

Үүний дараа (тэр үеийн албан ёсны нэрээр) Зөвлөлтийн эрдэмтэн Н. Ц. Мункуев “зээгт ав”, “ав хайдаг”-ийн талаар бие даасан томоохон өгүүлэл нийтлүүлж, түрүү үеийн эрдэмтэдийн холбогдох судлагааг бүрэнээ мөшхин сөхөж, хятад сурвалжийн мэдээг дэлгэрүүлэн

<sup>20</sup> Ш. Н-Р, Цыдэнжапов, *О происхождении устойчивого словосочетания “зээгтэ ав”*, - Материалы первого республиканской конференции молодых учёных по общественным наукам, Улан-Удэ, 1973, стр. 302-306;

<sup>21</sup> M. Swadesh, *Lexico-statistic dating of prehistoric ethnic contacts*, - Proceeding of the American philosophical society, Vol. 96, 1952, pp. 452-463; M. Swadesh, *Towards greater accuracy in lexicostatistic dating*, - International Journal of American Linguistics, Vol. XXI, 1955, pp. 121-137.

<sup>22</sup> Я. Цэвэл, *Монгол хэлний товч тайлбар толь*, Улаанбаатар, 1966, 297.6 тал.

<sup>23</sup> Т. А. Бертагаев, *Лексика монгольских языков*, - Докторская диссертация, Москва, 1946, 284 стр.

<sup>24</sup> С. Төмөр-очир, *Эртний монголчуудын ан агнуурийн зарим багаж зэвсэг, арга барилын тухай*, гар бичмэл, ШУА, Түүхийн хүрээлэнгийн номын сангийн гар бичмэлийн хөмөргө.

<sup>25</sup> Д. Гонгор, *Монголия в период от родового строя к феодализму*, Автореферат докторской работы, Улан-Батор – Москва, 1974, стр. 34-35; Д. Гонгор, *Халх товчоон*, II боть, Улаанбаатар, 1978, 354-р тал.

тайлбарлахын сац “зээг”, “дээс” гэх зэрэг холбогдох нэр томъёог монгол хэлний нутаг нутагийн аялгуунаас шүүрдэн дүгнэхдээ Т. А. Бертагаев, Д. Гонгор нарын саналыг үндсэнд нь зөвшөөрсөн байна<sup>26</sup>.

III. Энэхүү өгүүлэлийг бичигч миний бие эл судлагаанд “зээг” гэдэг үгийн шилжсэн өөр нэгэн утгыг халхын аялгууны баримтад шүтэж нэмэхсэн гэж хэдийнээс бодсоор ирсэн билээ. Монгол хэлний үгсийн санд “зээг” хэмээх нэр үгээс үүссэн “зээглэ-” гэдэг үйл үг буй бөгөөд түүнийг бичигийн хэлнээс илүүтэй, их төлөв аман ярианд өргөн хэрэглэгдэж байсаныг миний үеийнхин мэдэх боловч сүүлийн үесэд бараг хэрэглэгдэхээ байсан учир өдгөөгийн “хэнэггүй” зарим залуучууд бүр дуулаагүй ч байж мэднэ<sup>27</sup>.

“Монгол хэлний товч тайлбар толь”-д тэрхүү “зээглэ-” гэдэг үүсмэл үйл үгийг тайлбарласан нь:

ЗЭЭГЛЭ/Х I юманд зээг барьж оёх (Mo. *jegegle/kü*).

ЗЭЭГЛЭ/Х II жигдрэн зэргэцэх; зээглэж зогсох, зээглэж хоргоох<sup>28</sup>.

“Зэрэг, зэргэцэх” гэх зэрэг үгтэй язгуур нэг “зээг” гэдэг үг нь анх “нэгэн шугамаар зэргэцэхүй” гэсэн утгатай байсан байх бүрэн боломжтой бөгөөд үүнээс үүдэж тийнхүү хажиж хийсэн зүйл, тийнхүү хүрээлсэн зүйл гэсэн утгыг давхар илэрхийлэх болсон гэж үзэх үндэс буй. Тэгвэл “зээглэ-” гэдэг үйл үг, “тойруул-” гэдэг үгнээс ямар ялгаатай вэ? гэдэг асуулт гарна. Яг ижил утга илэрхийлсэн хоёр буюу хоёроос олон үг байж болох магадлалыг хэлшинжлэлийн ухааны үүднээс үгүйсгэдэг бөгөөд хэрэвзээ тийм үг байж гэмээ нь нэг нь нөгөөгөөсөө ялгарах утга олж байж хэлний хэрэгцээг хангах чадвартай болдог байна. Тэгвэл энэ хоёр үг ямар ялгаатай вэ? гэдэг асуулт дагаж гарах нь мэдээж. “Монгол хэлний товч тайлбар толь”-д жишээ болгож авсан “Зээглэж зогсох”, “зээглэж хоргоох” гэхэд монгол хүнд эргэн тойрон гэж ухагдахгүй, аль нэг талаараа “задгай, онгорхой, чөлөөтэй” гэж ойлгогдоно. Гэрийн зээгтэй дээвэр гэвэл их төлөв хормойгоороо, эсвэл хормой, хоолойгоороо л зээгтэй байдаг байлаа. Харин ширмэл ширдэг, зээгт наамал дээр, хэрэглээний талаасаа илүү, чимэглэлийн талыг нь зонхилодог, бас үүсэл хөгжилийн хувьд харьцангуй хожуу үед хамаардаг учир үүнээс арай өөр, дөрвөн талаар буюу эргэн тойрон зээглэсэн байх нь буй.

Ингэж бодвол “зээгт ав” гэдэг нэр томъёо нь уг ав хоморгын тухайд, авын хоёр жигүүр буюу хоёр гар нийлж амжаагүй, ав эхилэн тавьж буй үеийн үйл ажиллагааг анхлан нэрлэсэн гэж үзэж болно. Ав улам боловсронгуй болох явцад “хүн зээг”-ийн хажуугаар, модоор хашаа - зээг үйлдэх, тод өнгийн бөс даавуу унжуулсан зэл хэц татах зэрэг ан агнуурийн хялбарчилсан, хүн хүч хэмнэсэн элдэв олон арга гарсан байх нь мэдээж. Нэр томъёо гэдэг зүйл харьцангуй болзвол, тухайн ухагдахууны аль нэг онцлог тал, аль нэг хэлбэр, аль нэг онцлог хэсэг, аль нэг үүрэг, үйл явдалын аль гол хэсэгийг онцлон илэрхийлэн үүсээд яваандаа тухайн бүхэл бүтэн зүйлийн нэр болж хэвшидэг нь хэл бүрт нийтлэг үзэгдэл тул бидний судлагдахуун болж буй “зээгт ав” гэдэг нэр томъёо ч түүнээс ангид байх албагүй.

IV. “Зээгт ав”-ын талаар дээр өгүүлсэн бүх зүйлийг эргэн нэгэдхэж үзвэл: ямар ч атугай зээх авлах гэсэн нэрээс гарсан гэж үзэхэд, учир шалтгаан, монгол хэлний авиазүй, утга зүйн үүднээс эрхгүй эргэлзээ төрүүлнэ. Учир шалтгааны талыг доктор Д. Гонгор авгай нэлээд тодорхой тайлбарласан байна<sup>29</sup>.

<sup>26</sup> N. Ts. Münküev, *A Mongolian Hunting practice of the 13<sup>th</sup> century and the Buryat terms Zeegete aba and aba khaidag*, - Tractata Altaica, By Denis Sinor, Wiesbaden, 1976, pp. 417-433;

<sup>27</sup> Бидний аж төрөлийн өнөөгийн байдалаас харахад мэргэжлийн хэн нэгэн амьд хүний хэлсэн үгийг тоомсорлодоггүй, бичиг номд буй зүйлийг бараг үздэггүй хирнээ мэргэжлийн бус хүний цээжний бангаар хоосон цэцэрхэж, сайн сурталдсан зүйлийг мухар сохороор дагах аяс сүүлийн үест, ялангуяа залуучуудын дунд дэндүү газар авсаныг энэ ташрамд хэлэхэд яав ч илүүц болохгүй гэж санана. Монгол бичигийн хүмүүсээс хамагийн муухай хараал юу вэ? гэвэл “Өөрөө юу ч бүү мэд! Мэдсэн хүний үгэнд бүү ор!” гэсэн юм гэдэг хошин яриа байдаг. Харамсалтай нь, орчлонгийн жамаар, хаана ч гэсэн жинхэнэ номын хүн юм юман дээр хоосон цэцэрхээд, цоролзоод байдаггүй, бас өөрийгөө сурталдаад байдаггүй тул чоно борооноор гэгчээр биеэ үгүйлдэггүй хоосон цэцэд олширсоны шалтгаан нь тэр буй заа.

<sup>28</sup> Я. Цэвэл, *Монгол хэлний товч тайлбар толь*, Улаанбаатар, 1966, 297.6 тал.

<sup>29</sup> Д. Гонгор, *Халх товчоон*, II боть, Улаанбаатар, 1978, 351-361-р тал;

Эртний монголчуудын шашин шүтэлгэ, зан үйл, голлон эрхилэж ирсэн аж ахуйн нэгэн гол салбар – ав хоморгын хувьд бидний судлагдахуун болж буй “**зээгт ав**” гэдэг нэр томъёоны эхний үгийг түрэг зүгийн хэлнээс авсан буюу өөр хэлнээс монгол хэлэнд орсон үг гэж үзэхэд олон талын эргэлзээ төрнө. Юуны өмнө, монгол хэлний үгийн санд шууд холбон үзэх бүрэн боломж бүхий монгол үгийн хэлбэр төдийгүй түүний илэрхийлэх утга, түүнчилэн ан ав болон ер энгийн ахуй амьдрал дээрхи хэрэглээ нь тодорхой байгааг яагаад ч мартахаа аргагүй юм.

Я. Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь”-дахи (“зээг” >) “зээглэ/х” гэдэг үүсмэл үйл үгийн хоёрдугаар утга нь “зээг” гэдэг нэр үгийн хамагийн анхны бөгөөд одоо бараг мартагдахад хүрсэн “жигдрэн зэргэцэх” гэсэн утгыг хадгалаж байна гэж үзүүштэй. Үүнийг “Монгол хэлний товч тайлбар толь”-д уул үгийн орчин цагийн монгол хэлэн дэхи хэрэглээний талыг анхаарч хоёрдугаар утга гэсэн болохоос биш, монгол хэлний түүхэн утгазүйн үүднээс авч үзэж гэмээ нь нэгдүгээр утга нь байх ёстой бөгөөд ингэж үзэж байгаа минь, “**зээгт ав**” гэдэг нэр томъёоны мөн чанарыг лавшуулан тодруулах зорилгоор бичиж буй энэ өгүүлэлийн гол дүгнэлт болж байна. Өөрөөр хэлбэл “**зээгт ав**”- гэдэг нэр томъёо нь ав хоморгын тухайд олоноороо “жигдрэн зэргэцэж” зээглэн хашиж ан хийдэг үйл ажиллагаатай холбоотой үүссэн нэр гэж үзэж байна.

“Монгол хэлний товч тайлбар толь”-д буй “зээг” гэдэг үгийн “хэц, зэл” хэмээн тайлбарласан хоёрдугаар утга нь эртний монголчуудын ав хоморгын үед ан араатаныг харваач ангуучийн зүг үргээж хөөх зорилгоор янз бүрийн өнгө тод бөс даавуу тэргүүтэнийг унжуулсан зэл хэц, хүрээ татдаг байсан арга ажиллагаатай шууд холбогдолтой болох нь тодорхой байна. Тэхдээ энэ арга нь “**зээгт ав**”-ын хөгжилийн явцад ан авын үйл ажиллагааг хялбарчилан, хүн хүч хэмнэх зорилгоор харьцангуй сүүлд гарсан гэдэг нь маргаангүй юм.

“Зээг” татаж ан амьтан үргээдэг байсан эртний энэ уламжлал нь арай өөр утга хэлбэрээр өдгөө ч монголчуудын аж амьдралд байсаар байна гэж үзэх баримт буй. Үүнд: монголчууд өвчин зовлонтой үед гэр орондоо гадны хүн оруулахгүй гэж хөл хорихдоо үүд хаалганыхаа ойр, бүслүүрээсээ дээс унжуулан уядаг “*дээс татах*” ёс нь бөөгийн шашины итгэл үнэмшилтэй холбоотой, их л эртнээс уламжласан, өөрөөр хэлбэл гадны хүн болон түүнийг дагалдан ирж болзошгүй муу зүгийн ад шидийн зүйлийг оруулахгүй “үргээх” тэмдэг болсоор ирсэнийг давхар харуулж байгаа хэрэг.

“**Зээгт ав**” хэмээх энэхүү нэр томъёог буриад эрдэмтэдийн судлагаанд “зээгтэ аба” (зарим цөөн тохиолдолд “зээгээтэ аба”) гэж аман дуудалгадаа дөхүүлэн оросоор галиглаж тэмдэглэсэн нь зөвхөн аман дуудалгад хэт шүтэж, тэр дуудалга нь тухайн монгол үгийн үгзүйн хэлбэрээс холдсоны учир тийнхүү таамаг байдлаар янз бүрээр тайлбарлахад хүрсэн гэж үзэх үндэс буй. Энэ нь монгол бичигээр тов тодорхой (Mo. *jegeg* гэж) тэмдэглэсэн уг үгийг хэрхин бичдэг байдалыг анхаараагүйтэй холбоотой, хэрэвзээ анхаарсан бөгөөс зээх (Mo. *jigeke*) гэдэг амьтантай холбон үзэхгүй байсан буй заа. Мөн монгол бичигийн хэлбэрийн утга санаа нь тов тодорхой байсаар атал түрэг үг гэж үзэхгүй байсан буй заа.

Ямарваа нэгэн эртний үг хэлэлгэ, нэр томъёог үгийн гаралын талаас үзэх нь анхны уугуул утгыг тодруулах хамагийн найдвартай боломж олгодог билээ. Гэвч тухайн нэр томъёо, үг хэлэлгэ өргөн хэрэглээнээс гарсан тохиолдолд цагийн саалтаар өөр утгатай болчихдог байх тал буй боловч өнөөдөрийн хувиран өөрчилөгдсөн шууд утга болон монгол бичигээр хэрхин тэмдэглэдэг хийгээд баатарлагын тууль, ардын дуу, зүйр сэцэн үг, хэвшимэл хэлэлгэд хадгалагдан үлдсэн утгатай нь харьцуулан үзэх тохиолдолд уугуул утга нь тодрох явдал олонтаа гардаг<sup>30</sup>.

“**Зээгт ав**”- гэдэг нэр томъёог монгол хэлний үгсийн сан, үгийн гаралзүй, утгазүй, зан үйлийн талаас судлаж ийнхүү санал бодолоо нэмэрлэж байгаа минь одоо болтол эрдэмтэд санал нэгдэж чадаагүй уг сэдвийн цаашидын судлагаанд их бага аль нэгэн хэмжээгээр хэрэг болно гэж найдаж байна.

<sup>30</sup> Ц. Шагдарсүрэн, *Бөөгийн зохиол болон туулийн хэлний утга судлалын зарим асуудалд*, -Mongolian Studies (The Korean Association for Mongol Studies), N. 10 (2000), Seoul, 2001, pp. 117-127.